



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/322

Хэрлэн сум

Тавдугаар сургуулийг  
шинээр байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.7, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол, шинжлэх ухааны газрын дүгнэлтийг үндэслэн Хэрлэн сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт байрших 960 хүүхдийн хүчин чадалтай барилгыг түшиглэн байгалийн ухаан болон техник технологийн гүнзгийрүүлсэн сургалттай тавдугаар сургуулийг шинээр байгуулсугай.

2.Шинээр сургууль байгуулах ажлыг хууль дүрэм журмын дагуу зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө, мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Боловсрол шинжлэх ухааны газрын дарга (С.Мөнхцэцэг), дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллахыг Хэрлэн сумын Засаг дарга (М.Шүрэнцэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ